



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“БУМАН ДУСАЛ ББСБ” ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

2023.02.06 № 23/АД
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Буман дусал ББСБ” ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЕЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Д.Дашдулам ХХК гүйцэтгэх захирал, МНБ

1116216172 улс 6000797

"БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ
2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

БАЛАНС	(Төгрөгөөр)	
	12/31/2022	12/31/2021
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,096,474,985	262,535,204
Зээл (цэвэр)	8,593,353,320	7,832,045,785
Бусад авлага	772,556,950	207,437,370
Бусад хөрөнгө	42,363,249	42,883,425
Үндсэн хөрөнгө (цэвэр)	38,247,964	22,198,793
Биет бус хөрөнгө (цэвэр)	5,664,695	8,713,625
Нийт хөрөнгийн дүн	10,548,661,163	8,375,814,202
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,832,981,004	2,231,993,681
Бусад өр төлбөр	271,050,343	143,847,776
Хувьцаат капитал	2,627,170,000	2,627,170,000
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,683,000	4,483,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4,813,776,816	3,368,319,745
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10,548,661,163	8,375,814,202
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Хүүгийн орлого	2,483,682,698	1,834,084,962
Хүүгийн бус орлого	145,708,867	403,527,149
Хүүгийн зардал	(13,907,207)	(30,231,829)
Хүүгийн бус зардал	(798,858,374)	(499,404,592)
Болзошгүй эрдэлийн зардал	(209,140,928)	(152,484,231)
Үндсэн үйл ажиллагааны ашиг	1,607,485,056	1,555,491,460
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(10,019)	(24,691,445)
Татвар төлөхийн өмнөх ашиг	1,607,475,037	1,530,800,015
Орлогын албан татвар	(160,748,506)	(155,549,146)
Цэвэр ашиг (алдагдал)	1,446,726,531	1,375,250,869
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН		
Хувьцаат капитал	2,627,170,000	2,627,170,000
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,683,000	4,483,000
Хуримтлагдсан ашиг	4,813,776,816	3,368,319,745
Нийт эздийн өмчийн дүн	7,444,629,816	5,999,972,745
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	22,011,681,928	15,610,970,682
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	21,177,732,128	15,497,861,958
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	833,949,800	113,108,724
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	10,019	7,000,000
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(10,019)	(7,000,000)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	833,939,781	106,108,724
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	262,535,204	156,426,480
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,096,474,985	262,535,204

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно

